



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 284

Улаанбаатар хот

### Хаалттай өрийн бичгийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 165 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх, түүнд хяналт тавих журам”-ын 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Булл капитал ББСБ” ХХК-ийн хаалттай хүрээнд санал болгон гаргах 12 сарын хугацаатай, жилийн 18 хувийн хүүтэй, нэг бүр нь 1,000,000 /нэг сая/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 2,200 /хоёр мянга хоёр зуу/ ширхэг хаалттай өрийн бичгийг бүртгэсүгэй.

2. Хаалттай өрийн бичиг гаргахтай холбогдуулан хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Булл капитал ББСБ” ХХК /Х.Амгаланбаатар/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН